

**МОНГОЛ УЛС, АЗИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК
ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР (МӨЧЛӨГ СӨРСӨН БОДЛОГЫН
АРГА ХЭМЖЭЭГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР)-ИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ
ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 11 дүгээр
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийн төслийг Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаараа дээрх хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.


Төсөл санаачлагчийн зүгээс дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, геополитикийн хурцадмал байдлаас шалтгаалсан эдийн засагт үүсээд буй инфляц, төлбөрийн тэнцлийн сөрөг нөлөөллийг бууруулахад бодлогын дэмжлэг үзүүлэх, тус зээлийн хөрөнгөөр гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг дурдсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Н.Ганибал, М.Оюунчимэг нар гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгыг нь дэмжиж байгаа боловч зээлийн хөрөнгөөр төсвийн алдагдал нөхөхийг дэмжихгүй, зээлээ эргэн төлөх, ашгаа өгөх, үр дүнтэй зүйлд зарцуулах нь зүйтэй тул төслийг оруулж ирсэн энэ хэвээр нь дэмжих боломжгүй гэсэн саналыг хэлсэн болно.

Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийн төслийг зөвшилцөх асуудлаар санал хураахад Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ц.ЦЭРЭНПУНЦАГ